



ДУНДГОВЬ АЙМГИЙН
САЙНЦАГААН СУМЫН ЗАСАГ ДАРГЫН
ЗАХИРАМЖ

2021 оны 10 сарын 26 өдөр

Дугаар А/179

Мандалговь

Хүндэтгэл үзүүлэх тухай

Монгол Улсын Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 29 дүгээр зүйлийн 29.1.5 “а”, Төсвийн тухай хуулийн 14 дүгээр зүйлийн 14.2.3, Сангийн сайдын 2021 оны 61 дүгээр тушаалын 2 дугаар зүйлийн 2.1.5 дахь заалтыг тус тус үндэслэн ЗАХИРАМЖЛАХ нь:

1.Боловсрол шинжлэх ухааны салбар үүсэж хөгжсөний 100 жил, Монголын багш нарын 55 дахь өдөр, дэлхийн багш нарын 27 дахь өдрийг тохиолдуулан боловсролын байгууллагуудын удирдлагууд, багш нарт хүндэтгэл үзүүлсүгэй.

2.Арга хэмжээнд зарцуулагдах 1.835.250 (нэг сая найман зуун гучин таван мянга хоёр зуун тавин) төгрөгийг Засаг даргын нөөц хөрөнгөөс зарцуулахыг Тамгын газрын дарга (Ц.Лхагвасүрэн), ня-бо (О.Бямбасүрэн) нарт зөвшөөрсүгэй.

ЗАСАГ ДАРГА

С.БАТ-ОРГИЛ

Сумын Засаг даргын 2011 оны 10 сарын
26-ны өдрийн 1/129 дүгээр захирамжийн хавсралт

№	Нэр төрөл	Тоо	Нэг бүрийн үнэ	Нийт үнэ
1	Бэлгийн багц	15	70750	1061250
2	Ус	20	1500	30000
3	Хоол 1	20	10900	218000
4	Хоол 2	20	15900	318000
5	Салад	20	6900	138000
4	Лаазтай ундаа	20	3500	70000
Дүн 1.835.250				